

ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ТОЙМ

**ӨВӨР МОНГОЛД ЗОЧИЛСНОО
ЭРГЭН САНАХАД**

Ч. СҮРЭНЖАВ Хувьсгалт тэмцлийн
ахмад зүтгэлтэн

Манай ардын засаг төр үүсэн тогтносон анхныхаа өдрөөс эхлэн дэлхийн аливаа улс оронтой тэгш эрх, харилцан хүндэтгэх зарчмын үндсэн дээр холбоо харилцаа тогтоох чин эрмэлзлээ илэрхийлсэн бөгөөд энэхүү зарчимч чиг шугамыг бараг далан жилийн турш тууштай хэрэгжүүлсээр ирсний дүнд манай социалист эх орон- БНМАУ өнөөдөр дэлхийн зуу гаруй улс оронтой дипломат харилцаа тогтоож, эдийн засаг, соёлын харилцааг өдөр ирэх тутам өргөтгөн гүнзгийрүүлсээр байна.

Манай нам, ард түмэн ЗХУКН, аугаа их зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон эвдэршгүй холбоо, ах дүүгийнхээ найрамдлыг бүхий л талаар бэхжүүлэх явдлыг гадаад бодлогын үйл ажиллагааны гол чиглэл болгон хэрэгжүүлэхийн хамт социалист бусад орнуудтай тогтоосон ах дүүгийн найрамдал, нягт хамтынхаа ажиллагааг марксизм ленинизм, социалист интернационализмын зарчимд тулгуурлан зузаатгах чиг бодлогыг гуйвалтгүй баримталж ирсэн ба баримталсаар байна.

Ази тивийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, энэ бүс нутгийн улсуудын харилцан ойлгох, хамтран ажиллах явдлыг хөгжүүлэх үйлсэд бүхий л аргаар тус дөхөм үзүүлэх явдал бол манай нам, төрийн гадаад бодлогын үйл ажиллагааны нэн чухал хэсэг юм. Тийм ч учраас манай орон хөрш БНХАУ-тай сайн хөршийн ах дүүгийн харилцаа тогтоох асуудалд анхаарч ирсэн юм. МАХН-ын XIX их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэлдээ нөхөр Ж. Батмөнх: «БНМАУ Бүгд Найрамдах Хятад Ард Улстай харилцаагаа хэвийн болгох зарчимч чиг шугамаа тууштай баримталсаар байна» гэж дахин мэдэгдсэн нь үүнийг нотолж байна.

БНХАУ байгуулагдан, бүх Хятадын ард түмэн түүний дотор Өвөр Монголын ард түмэн харийн түрэмгийлэгчдийн савраас үүрд ангижран олон жилийн хоцрогдлыг арилгаж, шинэ амьдралыг байгуулах замд орсныхоо арван жилийн ойг 1957 оны 5 дугаар сарын 1-нд ёслол тэмдэглэсэн юм.

БНХАУ-ын засгийн газрын урилгаар Өвөр Монголын өртөө засах орны арван жилийн ойн баярт оролцох БНМАУ-ын нам, засгийн төлөөлөгчдийг би тэргүүлж явсан бөгөөд манай төлөөлөгчдийг Өвөр Монголын нийслэл Хөх хотод хүрэлцэн очиход нөхөр Улаанхүү тэргүүтэй удирдагчид болон ард түмэн нь элэгсэгт дотноор угтан баяр хүргэж, хүлээн авч, улмаар тус орны амьдрал байдал, хөгжилтэй танилцах боломжийг бүрэн олгосон юм.

Эдүгээ Өвөр Монголын өөртөө засах орны 40 жилийн ойн жил Тийнхүү гучин жилийн өмнө манай төлөөлөгчид тэнд зочилж арван жилийн нь ойн баяр ёслолд оролцож байсан тухайгаа нэхэн санаж өгүүлэхийг хүсэж байна. Тэр үед Өвөр Монголын хөгжил ямар болж байсныг юуны урьд товч дурдъя.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Хятадын олон сая ард түмэн ХКН-ын удирдлагын дор эрх чөлөөгөө олж авсан тэр үед Өвөр Монголын ард түмэн аз жаргалтай амьдрах бололцоотой болж, олон жилийн турш мөрөөдсөн үндэстний эрх чөлөөгөө эдлэн феодализмын гинжийг тас цохиж өргөн олон малчин, тариачин нь амуу будаагаа

чөлөөтэй тариалан, таван хошуу малаа чөлөөтэй бэлчээрлүүлж нийгмийн хуучин харьцааг өөрчилж социалист нийгмийн шинэ харьцааг бий болгоход чухал алхам хийсэн байв. Тэр хугацаанд Өвөр Монголын бүтээлч ард түмэн Хятадын олон сая ард түмний тусламжтай гаар улс төр, эдийн засаг, соёлын бүх салаа салбарт их амжилт олсон байлаа.

Тодорхой баримтаар дурдвал: эдийн засгийн чухал салбар болох мал аж ахуй түргэн хөгжиж, малын тоо 1947 онд 8 сая орчим байсан бол 1957 онд 24 сая болж өссөний дээр мал ба тариалан эрхлэх ардууд өөрийн сайн дураар улирлын ба сайн дурын хоршоололд нэгдэж хамтын хүчээр амьдралаа зохиож байв. Мөн хугацаанд Өвөр Монголын ард түмэн том жижиг 823 үйлдвэр байгуулсан бөгөөд бүх бүтээгдэхүүний 28,5 орчим хувийг үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байсан нь үйлдвэрийн талаар олсон томоохон амжилт болно. Барьж байсан Бугатын болд ширмийн үйлдвэр, Хянганы модны үйлдвэр бол хятад орон даяар гайхагдах томхон үйлдвэрүүдэд орж байв.

Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах арьс шир сүүний үйлдвэр, чихрийн завод, хөдөө аж ахуйн багаж хийх үйлдвэрүүд байгуулагдсан нь социалист байгуулалтын үе шатанд цоо шинэ салбар болсон байна. Шинээр байгуулагдсан аж үйлдвэрүүд нь сар, улирлын төлөвлөгөөг амжилттай биелүүлж ард олны материаллаг аж байдлыг дээшлүүлэх явдалд чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Аж үйлдвэр өсөхийн хамт ажилчин анги өсөж урьд үйлдвэрийн ямар ч мэргэжилгүй байсан малчид, тариачид үйлдвэрийн шинэ техник эзэмшиж ирээдүйдээ итгэлтэй зоригтой хөдөлмөрлөж байгаа нь бидэнд сайхан сэтгэгдэл төрүүлсэн билээ. Өөртөө засах засаг тогтносны сүүлийн жилд үйлдвэрт ажиллаж байсан монгол ажилтан ажилчдын тоо 10 дахин нэмэгдсэн нь үндэстний мэргэжилтэнтэй болж байгаагийн илрэл байсан билээ. Өвөр монголын ард түмний соёлын хэмжээ эрс дээшилж, сургуулийн сурагчдын тоо 12 түм гаруй болж, бараг 9 хүн тутмаас нэг нь суралцаж байв. Дээд сургууль 3, дунд сургууль 105, бага сургууль 9345 болсон байлаа.

Өвөр Монголын өөртөө засах орны нийслэл Хөх хотод болсон ойн баярын өргөн хуралдаанд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч н. Ли Сяньнянь тэргүүтэй төлөөлөгчид болон уйгар, казах, төвд зэрэг 20 гаруй үндэстэн, ястны төлөөлөгчид оролцож ах дүүгийн баяр хүргэж сайн сайхан бүхнийг ерөөж байсныг тод санаж байна.

Манай төлөөлөгчид тэр баярын хуралдаанд оролцож, Монголын ард түмний нэрийн өмнөөс ах дүүгийн халуун баяр хүргэж, Өвөр Монголын ард түмний арван жилийн дотор олсон амжилт ололтод чин сэтгэлийн баяр хүргэн бахархаж байгаагаа илэрхийлээд, монголын ард түмэн ардын хувьсгалт намынхаа удирдлагаар 1921 онд ардын хувьсгал хийж хувьсгалт засаг төрийг байгуулаад эх орондоо шинэ амьдрал байгуулах цоо шинэ замд орсноор гадаад, дотоодын хүнд нөхцөлд хатуу ширүүн сорилтыг туулан гарч, олон жилийн хоцрогдсон байдлыг арилган, улс орныхоо тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлж, түүхэн богино хугацаанд гайхамшигт амжилт олж, феодализмд социализмд шилжих түүхэн шилжилтийг хийж ирснээ зүй ёсоор бахархан тэмдэглэсэн билээ.

Өвөр Монголын ард түмэн, Монголын ард түмний төлөөлөгчид, урлагийн бригадынхныг үнэн сэтгэлээсээ халуун дотно, баяр баясгалан тайгаар угтан авч, манай орны төлөөлөгчдийн айлчлал хоёр орны

амьдралыг харилцан танилцаж, туршлагаа солилцож, социализм байгуулах нийтийн үйл хэрэгт чухал хувь нэмэр боллоо гэж үзэж байлаа.

Төлөөлөгчид бид нийслэл Хөх хотод хөдөлмөрчид, биеийн тамирчдын өргөн жагсаал, ойн баярын хурал, Хөх хотын улаан талбайд болсон дуу бүжгийн зочлох тоглолт болон 10 жилийн дотор олсон бүтээн байгуулалт, үндэстний ном хэвлэлийн үзэсгэлэн үзэж сонирхон, Жинин хотын мах комбинат, Бугат хотын болд төмрийн завод, Дүйнхэрийн сүм зэрэг газраар явж ажилчин, малчин ард олны амьдралыг нүдээр үзэж Өвөр монголын соёл боловсрол, эдийн засгийн хөгжилттэй танилцаж сайхан сэтгэгдэл төрж явсан юм.

Бид Хөх хотын улаан театр, Өвөр Монголын дуу бүжгийн бүлгэмийн тоглолтыг үзэв. Үндэстний урлагийн хөгжилтийг харуулсан 40 орчим номер багтаасан тэр тоглолтод нийт жүжигчдийн хувцас, чимэглэл, театрын тайз заслалыг үнэхээр хичээнгүйлэн сайтар бэлтгэсэн байв. Тоглолтын дотроос бүжгийн жүжигчдийн тоглосон Монгол үндэстний «саальчин», «адуучин», дагуур үндэстний «Ха-пу-бай» хятад үндэстний «Лянхуз» цэцэг, «савхан» бүжиг, нэрт дуучин Лхаажвын дуулсан «Жороо морь», «Гишигтэл сайтай» гэх зэрэг уртын дуу мөн нэрт дуучин Буяндэлгэрийн дуулсан «Саруул тал», «Эр бор харцага», Солонгос ардын дуу «Нотол мөрний дэнж» зэрэг нь үзэгч олны сонирхол талархлыг ихэд татан байлаа. «Зочлох» тоглолт нь монгол үндэстний өвөрмөц байдал болон Хятадын олон үндэстэн ястны нягтрал нэгдлийг тусган харуулаад «Асар» гэдэг дуу бүжиг хосолсон сайхан үзэгдлээр төгссөн билээ. БНМАУ-ын урлагийн бригад Хөх хот, Бугат, Жиин зэрэг олон газар зочлон тоглоход Өвөр Монголын үзэгчдийн сонирхлыг ихэд татаж талархлыг хүлээж байв. Монгол ардын дуу, монгол, хятад ардын дуу дуулсан жүжигчин Долгоржав, Сүрэнхорлоо, «Учиртай гурван толгой» дуурьт тоглосон жүжигчин Цэрэндондог, Цэрэндолгор нар олны таашаалыг хүлээж байлаа.

Өвөр Монголын болон Монголын урлагийнхан харилцан дуу бүжиг суралцаж урлагийн авьяас билэг, туршлагаа элэгсэг дотноор солилцож байлаа. Хөх хотод Монголын дүрслэх урлагийн үзэсгэлэнг нээгдсэнийг тэндэхийн хөдөлмөрчид олноороо сонирхож, өндөр сэтгэгдэлтэй байснаа санал сэтгэгдлийн дэвтэрт бичсэн бий. Зураачдын тосон будгийн зургийн чадварыг магтан үнэлж «Манай зураачид ах дүү Монгол зураачдаас сурах зүйл их байна» гэх зэргээр сэтгэгдлээ бичиж билээ.

Тэр 1957 оноос хойш дөчин жил өнгөрчээ. Өвөр Монголын ард түмэн энэ оны 8 дугаар сарын 1-нд 40 жилийнхээ ойг ёслол тэмдэглэхээр бэлтгэж байгаа нь өнгөрсөн оны 5 дугаар сард Өвөр Монголд хуралдсан ардын төлөөлөгчдийн уг чуулганы шийдвэрээс үзсэн что дорхой байна. Өнгөрсөн 40 жилийн хугацаанд Өвөр Монголын ард түмний улс төр, эдийн засаг, соёлын амьдралд багагүй бэрхшээл, саад тотгор тохиолдож байсан нь мэдээж боловч улс ардынхаа аж ахуй, соёлыг хөгжүүлэх үйл хэргийг үргэлжлүүлэн хүч чармайлт гаргасаар ирсэн нь бидэнд сайхан сэтгэгдэл төрүүлсээр байна.